



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 369

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, осолд орсны улмаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар оролцогч ирээгүй 276,300,000.00 (хоёр зуун далан зургаан сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 27,630,000.00 (хорин долоон сая зургаан зуун гучин мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн зохицуулагч Ж.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр), автомашины даатгалын нөхөн төлбөрийг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

(Huraldaanii material\2022 on\2022.09.08 20- huraldaan.docx 132002756

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
 569 дугаар тогтоолын хавсралт



”Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй
 дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглагдсан, орсон он	Үйлт, км (мнга)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоож, худалдах доод үнэ (төгрөг)
1	Ландкрузейр-200, 01-14 УБҮ. арал№JTMHX05J404220007 (осолд орсон)	2020/2020	11000	276,300,000.00	27,630,000.00	248,670,000.00	69,600,000.00
	Нийт дүн			276,300,000.00 (хоёр зуун далан зургаан сая гурван зуун мянган)	27,630,000.00 (хорин долоон сая зургаан зуун гучин мянган)	248,670,000.00 (хоёр зуун дөчин найман сая зургаан зуун далан мянган)	69,600,000.00 (жаран есөн сая зургаан зуун мянган)